



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2023/175/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 10</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
.....
 - 4.2 Материаллаг байдал
.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
.....
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.15 № 2/13

танай _____ -ны № _____ -т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Г **БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ У.БАЛЖИННЯМ ТАНАА** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.11.08-ны өдрийн 493 дугаар тогтоолоор тухайн байгууллагад бүртгэлтэй 171,925.0 мянган төгрөгийн 6877 метр квадрат газар эзэмших эрхээс 118,275.0 мянган төгрөгийн үнэ 4731 метр квадрат газрыг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас баланст шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.4 хувиар үнэлсэн байна.

005020139

D/2023-A4 Alban toot.doc

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Баянхонгор аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	125,456,673.09	117,683,977.59
33	АВЛАГА	4,246,977.00	2,827,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	791,343.00	0
33500	Бусад авлага	3,455,634.00	2,827,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,455,634.00	2,827,000.00
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	0
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	114,009,696.09	114,856,977.59
35100	Түүхий эд материал	41,347,612.96	45,675,810.46
35110	Тусгай зориулалттай материал	41,347,612.96	45,675,810.46
35400	Хангамжийн материал	66,040,083.13	62,559,167.13
35410	Бичиг хэргийн материал	2,902,596.00	3,544,746.00
35420	Аж ахуйн материал	43,613,215.00	45,196,549.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,861,400.00	115,000.00
35440	Түлш, шатах тослох материал	813,861.13	3,861.13
35450	Барилгын засварын материал	304,425.00	304,425.00
35470	Бусад хангамжийн материал	13,544,586.00	13,394,586.00
35600	Мал амьтад	6,622,000.00	6,622,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	606,008,445.37	463,077,539.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	606,008,445.37	463,077,539.84
39200	Биет хөрөнгө	431,253,445.33	408,167,539.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	349,700,950.00	349,700,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-42,946,315.60	-56,495,641.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,550,727.00	173,550,727.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-134,476,219.80	-140,265,035.64
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	115,226,847.51	132,701,047.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,558,857.50	-74,091,397.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,361,095.85	24,243,995.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,969,907.59	-16,437,542.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,483,854.78	22,483,854.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,118,729.32	-7,223,416.96
39300	Биет бус хөрөнгө	174,755,000.04	54,910,000.08
39301	Програм хангамж	7,780,000.00	7,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,949,999.96	-6,519,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	171,925,000.00	53,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	731,465,118.46	580,761,517.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,370,994.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,370,994.00	0
41300	Өглөг	1,370,994.00	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,313,094.00	0
41360	Бусад өглөг	57,900.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	57,900.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	730,094,124.46	580,761,517.43
51	Засгийн газрын хувь оролцоо	730,094,124.46	580,761,517.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	448,909,074.85	448,909,074.85
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	448,909,074.85	448,909,074.85
51101	Өмч /төрийн/	0	-118,275,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	195,371,651.71	164,314,044.68
51210	Өмнөх үеийн үр дүн	195,371,651.71	195,371,651.71
51220	Тайлант үеийн үр дүн		-31,057,607.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,813,397.90	85,813,397.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	731,465,118.46	580,761,517.43

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	670,567,877.26	408,264,681.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,937,917.26	83,149,681.90
120	Нийтлэг татварын бус орлого	176,937,917.26	83,149,681.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	100,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	26,815,967.11	16,274,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	150,121,950.15	66,775,281.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,629,960.00	325,115,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	446,203,500.00	293,117,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	446,203,500.00	293,117,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,426,460.00	31,997,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47,426,460.00	22,499,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	3,498,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	525,456,927.83	412,981,956.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,456,927.83	412,981,956.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,285,296.49	407,299,910.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,245,906.80	218,931,360.81
210101	Үндсэн цалин	149,084,402.00	171,323,131.57
210102	Нэмэгдэл	45,932,584.00	33,404,500.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,118,851.00	4,894,000.00
210104	Урамшуулал	10,110,069.80	9,309,729.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,062,613.38	27,003,287.00
210201	Тэтгэврийн даатгал	18,397,434.45	18,526,077.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,047,701.86	2,179,535.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,638,161.34	1,743,628.52
210204	Ажилгүйдлийн даатгал	387,524.27	414,003.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,591,791.46	4,140,041.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,662,900.00	17,055,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,353,300.00	2,778,153.12
210302	Түлш, халаалт	14,988,376.00	11,932,798.88
210303	Цэвэр, бохир ус	2,321,224.00	2,344,248.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,035,664.32	33,979,587.10
210401	Бичиг хэрэг	8,358,350.15	7,640,150.00
210402	Тээвэр, шатахуун	21,767,929.17	7,369,171.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,625,500.00	2,298,999.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,800.00	598,000.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,201,085.00	2,810,406.00
210408	Бараа материал актальсны зардал	4,049,000.00	13,262,860.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	0	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	5,325,600.00
210604	Урсгал засвар	800,000.00	5,325,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,524,500.00	1,609,000.00
210702	Дотоод албан томилолт	1,524,500.00	1,609,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,842,052.00	34,924,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,013,660.00	25,121,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	168,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	504,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,592.00	183,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,740,000.00
210807	Газрын төлбөр	347,800.00	1,130,498.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,111,659.99	68,470,885.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,598,000.00	25,457,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,513,659.99	43,013,005.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,171,631.34	5,682,045.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,075,475.00	1,724,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,875,500.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,199,975.00	1,724,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,096,156.34	3,957,445.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,096,156.34	3,957,445.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	145,110,949.43	-4,717,274.53
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	150,000,000.00	26,340,332.50
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	150,000,000.00	26,340,332.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,889,050.57	-31,057,607.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	493,629,960.00	325,215,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,629,960.00	325,115,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	446,203,500.00	293,117,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	446,203,500.00	293,117,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,426,460.00	31,997,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47,426,460.00	22,499,500.00

Баянхонгор аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	3,498,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	490,965,360.00	323,132,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,965,360.00	323,132,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,139,303.66	317,450,254.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,865,468.32	218,882,377.81
210101	Үндсэн цалин	152,649,141.52	172,309,352.57
210102	Нэмэгдэл	41,239,406.00	33,404,500.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,866,851.00	4,894,000.00
210104	Урамшуулал	10,110,069.80	8,274,525.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,117,383.34	27,003,287.00
210201	Тэтгэврийн даатгал	18,389,812.72	18,526,077.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,046,936.22	2,179,535.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,637,566.06	1,743,628.52
210204	Ажилгүйдлийн даатгал	367,543.16	414,003.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,675,525.18	4,140,041.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,662,900.00	17,055,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,353,300.00	2,778,153.12
210302	Түлш, халаалт	14,988,376.00	11,932,798.88
210303	Цэвэр, бохир ус	2,321,224.00	2,344,248.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,125,400.00	11,645,499.20
210401	Бичиг хэрэг	2,137,100.00	2,904,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,624,600.00	5,293,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,625,500.00	2,298,999.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,800.00	598,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	704,400.00	550,600.00
2105	Нормативт зардал	524,800.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	524,800.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,958,400.00	5,425,600.00
210604	Урсгал засвар	4,958,400.00	5,425,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,524,500.00	1,609,000.00
210702	Дотоод албан томилолт	1,524,500.00	1,609,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,360,452.00	32,702,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,332,060.00	30,099,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	168,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	504,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,592.00	183,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	347,800.00	1,130,498.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	3,126,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	3,126,300.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,826,056.34	5,682,045.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,729,900.00	1,724,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,875,500.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,854,400.00	1,724,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,096,156.34	3,957,445.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,096,156.34	3,957,445.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,664,600.00	2,082,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,664,600.00	2,082,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,664,600.00	2,082,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,664,600.00	2,082,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,664,600.00	2,082,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,664,600.00	-2,082,700.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.28	733,656,575.03
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,909,074.85	84,486,797.90	200,260,702.28	733,656,575.03
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	1,326,600.00	0	1,326,600.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-4,889,050.57	-4,889,050.57
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,909,074.85	85,813,397.90	195,371,651.71	730,094,124.46
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,909,074.85	85,813,397.90	195,371,651.71	730,094,124.46
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,909,074.85	85,813,397.90	195,371,651.71	730,094,124.46
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-118,275,000.00	0	0	-118,275,000.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-31,057,607.03	-31,057,607.03
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	164,314,044.68	580,761,517.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Баянхонгор аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,117,500.00	292,758,054.01	359,445.99	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,117,500.00	292,758,054.01	359,445.99	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,392,900.00	291,033,454.01	359,445.99	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,884,500.00	218,882,377.81	2,122.19	100.0
210101	Үндсэн цалин	166,308,400.00	172,309,352.57	(6,000,952.57)	103.6
210102	Нэмэгдэл	38,152,100.00	33,404,500.24	4,747,599.76	87.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,077,000.00	4,894,000.00	183,000.00	96.4
210104	Урамшуулал	9,347,000.00	8,274,525.00	1,072,475.00	88.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,360,600.00	27,003,287.00	357,313.00	98.7
210201	Тэтгэврийн даатгал	18,605,200.00	18,526,077.07	79,122.93	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	2,188,800.00	2,179,535.67	9,264.33	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,751,100.00	1,743,628.52	7,471.48	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	437,800.00	414,003.87	23,796.13	94.6
210205	Эрүүл мэндийн даатгал	4,377,700.00	4,140,041.87	237,658.13	94.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,055,200.00	17,055,200.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	749,200.00	2,778,153.12	(2,028,953.12)	370.8
210302	Түлш, халаалт	13,961,800.00	11,932,798.88	2,029,001.12	85.5
210303	Цэвэр, бохир ус	2,344,200.00	2,344,248.00	(48.00)	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,645,500.00	11,645,499.20	0.80	100.0
210401	Бичиг хэрэг	2,904,300.00	2,904,300.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,293,600.00	5,293,600.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,299,000.00	2,298,999.20	0.80	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	598,000.00	598,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	550,600.00	550,600.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,508,300.00	7,508,300.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,082,700.00	2,082,700.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,425,600.00	5,425,600.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,609,000.00	1,609,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,609,000.00	1,609,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,203,500.00	4,203,490.00	10.00	100.0

**Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,600,000.00	1,600,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	168,100.00	168,100.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	504,300.00	504,300.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,600.00	183,592.00	8.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	540,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,130,500.00	1,130,498.00	2.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,300.00	3,126,300.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,300.00	3,126,300.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,724,600.00	1,724,600.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,724,600.00	1,724,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,724,600.00	1,724,600.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	293,117,500.00	292,758,054.01	359,445.99	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	293,117,500.00	292,758,054.01	359,445.99	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	293,117,500.00	292,758,054.01	359,445.99	99.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22.00	22.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,426,460.00	28,499,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,426,460.00	28,499,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,426,460.00	28,499,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,426,460.00	28,499,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,426,460.00	28,499,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,498,000.00

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,498,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,426,460.00	31,997,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,426,460.00	31,997,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	22,499,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,426,460.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,498,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинэжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, бүтээгдэхүүний нэр төрлийг сайжруулах, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаарх төр, эдийн засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, малчид, тариаланчид, иргэдийг мэдээ, мэдээлэл, мэргэжил, арга зүй, технологийн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, шуурхай хүргэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ХХААХҮЯ-ны дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/385 дугаартай тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бичиг” холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 446,463.2 мянган төгрөг болж өмнөх оноос 161,202.9 мянган төгрөгөөр буюу 56.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	11,447.0	2,827.0	-8,620.0
Бараа материал	114,009.7	114,857.0	847.3
Үндсэн хөрөнгө	864,028.5	764,110.6	-99,917.9
Хуримтлагдсан элэгдэл	-258,020.0	-301,033.0	-43,013.0
Нийт хөрөнгө	731,465.1	580,761.5	-150,703.6
Өр төлбөр	1,371.0		-1,371.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	730,094.1	580,761.5	-149,332.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	731,465.1	580,761.5	-150,703.6

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 2,827.0 мянган төгрөг болж өмнөх оноос 8,620.0 мянган төгрөгөөр буурсан нь санхүү, төсвийн төслийн программын 7,200.0 мянга, ажиллагсадтай холбоотой 791.3 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулсантай холбоотой бөгөөд тайлант оны эцэст тухайн байгууллагад ажиллаж байсан малчинтай холбоотой 2,827.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 114,857.0 мянган төгрөг болж өмнөх оноос 847.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 17,340.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 66,775.3 мянга бүгд 84,115.8 мянган төгрөгийн орлого авч 83,268.6 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Тайлант онд ХХААХҮЯ-аас 20,614.3 мянга, аймгийн орон нутгийн төсвөөс 45,881.9 мянга, бусад эх үүсвэрээс 279.1 мянга төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч 26,340.3 мянган төгрөгийн бараа материалыг сумдын ЗДТГ-т үнэ төлбөргүй шилжүүлсэн, Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2022.06.08-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар 3,814.9 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 764,110.6 мянган төгрөг болж өмнөх оноос 99,917.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2,082.7 мянга,

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ХХААХҮЯ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 16,274.4 мянга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.11.08-ны өдрийн 493 дугаар тогтоолоор тухайн байгууллагад бүртгэлтэй 171,925.0 мянган төгрөгийн 6877 метр квадрат газар эзэмших эрхээс 118,275.0 мянган төгрөгийн үнэ 4731 метр квадрат газрыг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас баланст шилжүүлсэн байна.

Тайлант оны эхэнд 1,371.0 мянган төгрөгийн өглөгтэй байсан оны эцэст өглөггүй байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 580,761.5 мянган төгрөг болж 149,332.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 149,332.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 312,632.1 мянга, нийт зарлагыг 312,632.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 102,238.1 мянган төгрөгөөр бууруулж 210,394.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 238,899.5 мянган төгрөг болгож 28,505.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70805, 72101 хөтөлбөрийн 80101, 80802, арга хэмжээг санхүүжүүлэхээр 291,517.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 291,517.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 293,117.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 100.0 мянган төгрөг төвлөрч оны эцэст 459.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 292,758.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 359.4 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70805 Хүнс, хөдөө ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого, удирдлага	291,517.5	291,158.1	359.4	99.8
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	289,792.9	289,433.5	359.4	99.8
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,724.6	1,724.6	0	0
4	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,600.0	1,600.0	0	0
	Нийт дүн	293,117.5	292,758.1	359.4	99.8

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030019401 тоот дансанд 31,997.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 28,449.5 мянган төгрөгийн зарцуулж улсын төсөвт 3,498.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

/мянган төгрөгөөр/

д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Аймгийн Засаг даргын 2022.04.12-ны өдрийн А/235 дугаар захирамж/Бог малын хээлтүүлэгчийн үзлэг ангилалтын үйл ажиллагааг зохион байгуулах тухай/	19,999.5
2	Аймгийн Засаг даргын 2022.12.01-ны өдрийн А/726 дугаар захирамж //Хүнсний бус зориулалтын хуванцар савны аяны зардал 3.2.2/	2,500.0
3	ХАА-н бирж	3,000.0
4	Жижиг дунд үйлдвэрийн газар /Хоршооны хөгжлийг дэмжих жил" хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ/	3,000.0
5	Үрийн үнэ	3,498.0
	Нийт орлогын дүн	31,997.5

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 30-ны өдрийн 378 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Балжинням, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнх-Оргил нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 293,117.5 мянган төгрөгөөс тооцоход 4,396.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 3,077.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус салбар нь 888,125.1 мянган төгрөгийн төсөв батлагдан төсвийг бүрэн зарцуулсан ба байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардлыг батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулсан бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	1	1	2
2	Хагас жил	4	4	4	0		
3	Улирал бүр	1	4	4	0		
4	Сар бүр	3	36	33	3		
5	Тухай бүр	8	96	92	4		
	Нийт	27	151	140	8	1	2

Тус байгууллага нь 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8 мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээлэл байршуулаагүй байна.

Үүнд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 308,483.4 мянган төгрөгийн 13 гүйлгээ байршуулахаас 1 мөнгөн гүйлгээний 25,995.6 мянган төгрөгийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 11757.5 мянган төгрөгийн 1 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 4,724.6 мянган төгрөгийн 11 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 164,724.7 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 628.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 139,025.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1,313.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 23,758.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2022.09.30-ны өдрийн 299 дүгээр албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,313.1	1	1,313.1	100
Албан шаардлага	1	139,025.0	1	139,025.0	100
Зөвлөмж	3	23,758.0	3	23,758.0	100
Нийт дүн	5	164,096.1	5	164,096.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,340.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 26,340.3 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залрууллаа.

1.Тусгай зориулалтын хөрөнгөнд бүртгэгдсэн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 24,844.0 мянган төгрөгийн усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор усалтын системүүдэд шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмжийг Баянлиг, Бууцагаан сумдад, 1,496.3 мянган төгрөгийн ХХААҮЯ-наас нийлүүлсэн мал жинлэгч, туузан метрийг 10 сумдад тус тус үнэ төлбөргүй шилжүүлсэн бөгөөд нягтлан бодогч санхүүгийн тайландаа бараа материал шилжүүлсний зардлаар 24,844.0 мянга, үнэ төлбөргүй гарсан зардлаар 1,496.3 мянга гэж тайлагнасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Иймд 26,340.3 мянган төгрөгийг "Үнэ төлбөргүй гарсан зардал-бараа материал"-225011 дансанд бичиж санхүүгийн тайланд залруулах

Аудитаар нийт 3,350.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,350.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдааг давтан гаргахгүй зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын албан хэрэгцээний автомашинд Баянхонгор сум дотор 299.9 мянган төгрөгийн шатахуун төсвөөс зарцуулан ашигласан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2. "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан шатахууны 299.9 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын даргын 2022.12.13-ны өдрийн Б/47 дугаар тушаалаар нийт албан хаагчдын эрүүл мэнд дархлааг дэмжих зорилгоор 900.0 мянган төгрөгийн олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3. "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар нэг удаагийн тэтгэмжийн зардлаас зарцуулсан 900.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Аймгийн Түүхт 80 жилийн ойд зориулж малчдаас хандив тусламж өгсөн малчдад талархал илэрхийлж "Батламж" хэвлүүлсний зардалд Аймгийн ХХААГ-ын даргын 2022.10.17-ны өдрийн А/36 дугаар тушаалаар 1,326.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5. "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 1,326.3 мянган төгрөгийн батламжийн үнийг байгууллагын даргаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт Тус байгууллага нь 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8 мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээлэл байршуулаагүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 мэдээллийн 25,995.6 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг үнэн зөв мэдээлж байх.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тусгай зориулалтын хөрөнгөнд бүртгэлтэй 26,340.3 мянган төгрөгийн материалыг сумдад үнэ төлбөргүй шилжүүлэхдээ э буруу бүртгэсэн	1	26,340.3					1	26,340.3				
Дүн	1	26,340.3					1	26,340.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Баянхонгор сум дотор 299.9 мянган төгрөгийн шатахуун төсвөөс зарцуулсан байна	1	299.9	1	299.9								
Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас дархлааг дэмжих зорилгоор 900.0 мянган төгрөгийн олгосон байна.	1	900.0	1	900.0								
Аймгийн Түүхт 80 жилийн ойд зориулж малчдаас хандив тусламж өгсөн малчдад талархал илэрхийлж "Батламж" хэвлүүлсний зардалд 1,326.3 мянган төгрөг зарцуулсан байна.	1	1,326.3	1	1,326.3								
Дүн	3	1,326.3	3	1,326.3								

Баянхонгор аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийн бүрэн оруулаагүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0					1	0

ooOoo